Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2021 онд тус төсөвт байгууллагуудын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, шалгалтаар 19.8 сая төгрөгийн акт тогтоосны 16.7 сая төгрөгийг барагдуулсан байна.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 7265.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 72.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 86 хувиар буюу 43.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 146.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 125.3 сая төгрөг болж, 21.0 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	146.3	125.3	-21.0	14.4
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>146.4</b>	<b>125.3</b>	<b>-21.0</b>	<b>14.4</b>

*Эх сурвалж: Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 125.3 сая төгрөг байгаагаас 25.0 сая төгрөг нь сумын орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 50.9 сая төгрөг нь ОНХСангийн, 47.8 сая төгрөг нь СХСангийн, 1.2 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын, 0.4 сая төгрөг арилжааны банкинд дахь Эргэлтийн эмийн сангийн дансны үлдэгдэл байна.

**Аудитын илрүүлэлт:**

*Тус сумын ТШЗ-ийн тайлангаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй байна.*

#### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

#### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 380.1 сая, эцсийн үлдэгдэл 414.3 сая төгрөг болж, 34.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	28.4	3.2	-25.2

Төлбөртэй үйлчилгээний авлага		46.4	46.4
Татаас, санхүүжилтийн авлага			-
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага	6.6	0.0	6.6
Зээлийн авлага	345.1	364.7	19.6
<b>Дүн</b>	<b>380.1</b>	<b>414.3</b>	<b>34.2</b>

Эх сурвалж: Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай авлага байхгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэл 364.7 сая төгрөг байгаа нь нийт авлагын 88.0 хувийг эзлэж, тайлант онд авлагын эргэн төлөлтөөс нэмж зээл олгосноор авлага нэмэгдсэн байна. Зээлийн хүүгийн авлагыг тусад тооцоолоогүй байна.

Төсөвт байгууллагуудаас сумын Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 46.4 сая төгрөгийн санхүүжилтийн авлага шинээр нэмэгдэж, ажиллагсадтай холбоотой ЗДТГ 1.8 сая, Хөх хөтөлийн цэцэрлэг 0.4 сая, Соёлын төв 1.0 сая нийтдээ 3.2 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

Тус сумын ТШЗ-ийн тайлангаар авлагатай холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

#### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

#### 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

#### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 761.3 сая, эцсийн үлдэгдэл 611.0 сая төгрөг болж, 150.3 сая төгрөгөөр буурсан байна.

##### Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	24.0	20.5	-3.5
Хангамжийн материал	727.4	580.6	-146.8
Мал амьтад	9.9	9.9	0.0
<b>Дүн</b>	<b>761.3</b>	<b>611.0</b>	<b>-150.3</b>

Эх сурвалж: Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 611.0 сая төгрөг болж 150.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд сумын төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр 660.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 42.9 сая төгрөгийн материал үнэгүй төлбөргүй, 19.6 сая төгрөгийн материалыг бусад эх үүсвэрээс хүлээн авч данс бүртгэлд тусган, үйл ажиллагаандаа 760.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 112.4 сая төгрөгийн материалыг акталсан байна.

Бараа материалын нийт үлдэгдлийн 352.2 сая төгрөг нь Ерөнхий боловсролын сургуулиудын, 149.5 сая төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгүүдийн, 78.9 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 30.4 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудын үлдэгдэл байна. Сумын ЭМТ-ийн материалын үлдэгдэл өмнөх оноос нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор худалдан авсан, үнэгүй хүлээн авсантай холбоотой материалын үлдэгдэл нэмэгдсэн байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

Сумын төсөвт байгууллагуудын тайлангаар бараа материалын данстай холбоотой дараах зөрчил дутагдал гарсан байна.

Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүд дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний материалыг хэрэгцээнээс илүү хэмжээгээр нөөцөлж бараа материалын үлдэгдлийг их хэмжээгээр нэмэгдүүлсэн байна. Энэ нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэн нөгөө талаар сумын санхүү, төрийн сангаас нормативт зардлын төсвийн зарцуулалтад хүүхдэд өдрийн гүйцэтгэлээр хяналт тавьж ажиллаагүй, хяналт хангалтгүй хийгдсэнтэй холбоотой өмнөх оны санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

Оны эцэст Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 53.9 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 30.0 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй байгаа нь хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлсөн гэж үзэх үндэстэй ба чанар байдлаа алдаж муудах, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй байна.

Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль хүнсний бараа материал дансанд урьд жилүүдэд хоолны зардлын төсвөөс авсан гэх материалыг бүртгэж ирснээс 17.4 сая төгрөгийг үндсэн хөрөнгөнд шилжүүлэн, 3.1 сая төгрөгийн материалыг данснаас хасахдаа тооцоо үнэн зөв эсэхийг сумын санхүүгийн албаар хянуулж баталгаажуулаагүй, хөрөнгийг данснаас хасах талаар тушаал шийдвэр гаргаж албажуулан баримтжуулаагүй байна.

Мөн дотуур байрны хүүхдүүдийн хоолонд Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормыг 1.4 төгрөгөөр хэтрүүлэн төсвөөс илүү зарлага гаргасныг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Согоог хүүхдийн цэцэрлэг өмнөх оны аудитаар хүнсний материалын тооллогоор илэрсэн 33.6 сая төгрөгийн зөрчлийн мөрөөр хүнсний материалын данснаас 29.0 сая төгрөгийн материалыг хасаж үүнээс 4.8 сая төгрөгийг үндсэн хөрөнгөд шилжүүлж, 22.3 сая төгрөгийг зардалд бичихдээ бүрдүүлсэн материалын үнэн зөвийг сумын санхүүгийн албаар хянаж баталгаажуулаагүй, бараа материал данснаас зарлага гаргах тухай тушаал шийдвэр гаргаж албажуулаагүй байна. Бараа материалаас үндсэн хөрөнгөд шилжүүлсэн 4.8 сая төгрөгийн залруулах бичилтийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэж тайлант үеийн орлогыг нэмэгдүүлснийг залрууллаа.

Хөх хөтөлийн цэцэрлэг нь хүнсний материалын данснаас урьд жилүүдэд хоолны зардлын төсвөөс авсан гэх 16.7 сая материалыг хүнсний материалаар бүртгэж ирснийг цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар 6.5 сая төгрөгийг үндсэн хөрөнгөд, аж ахуйн материалын дансанд 4.8 шилжүүлэн, 5.4 сая төгрөгийн материалыг зарцуулснаар данснаас хасахдаа бүрдүүлсэн баримтууд нь тухайн үед бүрдүүлсэн баримт эсэх нь эргэлзээтэй, үнэн зөвийг сумын санхүүгийн албаар хянаж баталгаажуулаагүй байна.

Эрүүл мэндийн төвийн жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 1.0 сая төгрөгийн аж ахуйн, 6.8 сая төгрөгийн хүнсний материал дутсаныг санхүүгийн тайланд үлдэгдлээр тайлагнаж ирүүлсэн байна.

Сумын төсөвт байгууллагуудаас бараа материалтай холбоотой илэрсэн дээрх зөрчлүүдэд зөрчлийн шинж байдлыг харгалзан акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдсөн.

#### **3.5.7 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 16557.8 сая, эцсийн үлдэгдэл 17656.3 сая төгрөг болж, 1098.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	16,441.0	17540.3	1099.3
Биет бус хөрөнгө	116.8	116.0	-0.8
<b>Дүн</b>	<b>16,557.8</b>	<b>17656.3</b>	<b>1098.5</b>

Эх сурвалж: Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 56.4 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 2202.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 94.5 сая төгрөгийн хөрөнгө акталсан байна. Дуусаагүй барилга дансны оны эхний 404.0 сая төгрөгийн үлдэгдлийг барилга байгууламжийн дансанд хөрөнгөөр шилжүүлэн бүртгэж үлдэгдэлгүй гарсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

Сумын төсөвт байгууллагуудын тайлангаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой дараах зөрчил дутагдал илэрсэн байна.

Сумын төвийн Хүүхдийн цэцэрлэг нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 123 дугаар тогтоолоор 29.8 сая төгрөгийн, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 54 дугаар тогтоолоор 303 төрлийн 29.9 сая төгрөгийн хөрөнгийг актлах тухай зөвшөөрөл олгосон боловч Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж, дүгнэлт гаргуулаагүй, байгууллагын даргын шийдвэрээр акталж, устгал хийгээгүй байна.

Хөх хөтөлийн цэцэрлэгийн жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгдсэн боловч зарим хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүн нь санхүүгийн тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй, зарим хөрөнгийн үлдэгдлийг бүрэн тоолоогүй, нягтлан бодогч нь тооллогын дүнг үндэслэн тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс нийтдээ 86.5 сая төгрөгийн зөрчилтэй байна.

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 174.0 сая, эцсийн үлдэгдэл 134.4 сая төгрөг болж, 39.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт: №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	15.8	6.0	-9.8	4.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг				
Байгууллагад төлөх өглөг	152.9	128.2	24.7	95.7
Хувь хүмүүст төлөх өглөг	5.3	0.2	-5.1	0.1
<b>Нийт дүн</b>	<b>174.0</b>	<b>134.4</b>	<b>39.6</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн жилийн эцсийн үлдэгдэл 134.4 сая төгрөгийн 95.7 хувийг буюу 128.2 сая төгрөгийг байгууллагад төлөх, 4.5 хувийг буюу 6.0 сая төгрөгийг ажилчидтай холбоотой, 0.1 хувь буюу 0.2 сая төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөг эзэлж байна.

ЗДТГ 4.6 сая, ЕБ-ын 1 дүгээр сургууль 3.5 сая, 2 дугаар сургууль 9.1 сая, 3 дугаар сургууль 11.0 сая, 1 дүгээр цэцэрлэг 3.1 сая, 2 дугаар цэцэрлэг 2.2 сая, 3 дугаар цэцэрлэг 3.4 сая, Соёлын төв 7.6 сая төгрөгөөр өглөгөө оны эхнээс бууруулж, сумын ИТХ 3.9 сая, ЭМТ 3.0 сая төгрөгөөр өглөгөө нэмэгдүүлсэн байна .

**Аудитын илрүүлэлт:**

Сумын төсөвт байгууллагуудын тайлангаар өглөгтэй холбоотой зөрчил дутагдал гараагүй байна

**3.5.9 Засгийн газрын хувь оролцоо**

Хүснэгт №6 Засгийн хувь оролцоо

/сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+/ бууралт /-/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,371.1	4,371.1	0	23.4
Хуримтлагдсан үр дүн	6,828.6	7,852.7	1024.1	42.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,472.0	6,448.8	-23.2	34.5
<b>Дүн</b>	<b>17,671.7</b>	<b>18,672.6</b>	<b>1000.9</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 18672.6 сая төгрөг болж 1009.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл акталсан хөрөнгөтэй холбоотой 23.2 сая төгрөгөөр буурсан байна. Хуримтлагдсан үр дүн 7852.7 сая төгрөг болж 1024.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

**3.5.10. Орлогын данс**

Улаанхус сум нь 2021 онд гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 233.2 сая төгрөгийн орлого оруулж, тусламж санхүүжилтийн орлогоор тусгай зориулалтын шилжүүлгээс 5819.0 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 921.5 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 107.4 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 309.2 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 62.6 сая төгрөг оруулан, үнэ төлбөргүйгээр 2245.2 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалыг хүлээн авч, нийтдээ 9698.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого 9698.1 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 1768.2 сая төгрөгөөр буюу 22.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орон нутгийн орлого, төсвийн урсгал, нэмэлт санхүүжилт, орон нутгийн төсөв, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материал, ЭМД-ын сангийн санхүүжилт байна.

**3.5.11 Зардлын данс**

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 8369.3 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 1103.6 сая төгрөгөөр буюу 15.2 хувиар өссөн байна.

Нийт зардлын 97.5 хувь нь бараа үйлчилгээний зардал, 2.5 хувь нь урсгал шилжүүлэг байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, томилолт, зочны зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд 0.1-684.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

Сумын төсөвт байгууллагуудын тайлангаар зардлын данстай холбоотой дараах зөрчил илэрсэн байна.

ЕБ-ын 3 дугаар сургууль нь оны эхний 11.6 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, татварын авлагыг хоорондын тооцоогоор барагдуулсан боловч 11.2 сая төгрөгийн өглөгтэй гарч өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, 11.0 сая төгрөгөөр хөрөнгө худалдан авсан, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.2-д заасныг зөрчиж өндөр насны тэтгэвэрт гарсан хүний оронд шинээр нэг хүн ажилд авч 2.3 сая төгрөгийн цалингийн зардал гаргаж төсвийн хэмнэлт гаргах талаар санаачилга гаргаж ажиллаагүй байна.

Мөн тайлант онд хангамж, бараа материалын зардал, байр ашиглалт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, томилолтын зардал, норматив зардлын нийт 6.1 сая төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчиж үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад тэвчиж болох бусад урсгал зардалд ЕБ-ын 2 дугаар сургууль 3.2 сая төгрөгөөр, Согоог хүүхдийн цэцэрлэг 0.8 сая төгрөгөөр төсвийг хэмнэж ажиллаагүй байна.

Дээрх зөрчлүүдэд албан шаардлага, зөвлөмж өгөгдсөн байна.

### **3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тайлант онд Улаанхус сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 7229.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 7014.9 сая төгрөгийг урсгал зардалд, 214.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 5819.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 949.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 214.6 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 66.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 180.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Улаанхус сум нь 2021 онд гүйцэтгэлээр нийтдээ 7200.1 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлснээс тусгай зориулалтын шилжүүлгээс 5808.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 949.1 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 61.0 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 214.6 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 166.6 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 166.6 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Нийт санхүүжилтээс 10.2 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн ба орон нутгийн төсвөөс 33.6 сая төгрөгийн, ЭМДС-гаас 5.5 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, үндсэн үйл ажиллагааны орлого 13.4 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7209.0 сая төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлоготой холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2020 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор Улаанхус сумын 2021 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 166.6 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 2021 оны 41 дүгээр тодотголоор 211.6 сая төгрөгөөр буюу 45.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 25 дугаар хуралдааны тогтоолоор 2021 орлогын төлөвлөгөөг 211.6 сая төгрөгөөр хэвээр нь баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 233.2 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 21.7 сая төгрөгөөр буюу 10.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт №7 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	198.8	185.4	-13.4	79.5
II.Татварын бус орлого	12.8	47.8	35.0	20.5
<b>Нийт дүн</b>	<b>211.6</b>	<b>233.2</b>	<b>21.7</b>	<b>100.0</b>

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд татварын орлогоос үйл ажиллагааны орлогын албан татвар 8.8 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 2.1 сая төгрөгөөр, бууны албан татвар 2.8 сая төгрөгөөр, газрын төлбөр 1.9 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хураамж 4.8 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 3.8 сая төгрөгөөр, ойн нөөцийн төлбөр 1.0 сая төгрөгөөр, агнуурын нөөцийн төлбөрөөс 4.1 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний давж биелэгдэхэд иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлого 4.4 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 11.6 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 1.4 сая төгрөгөөр давж биелэгдэн, төлөвлөгөө өгөгдөөгүй малын албан татварын орлогоос 29.4 сая төгрөгийн, бусад нэр заагдаагүй орлогоос 4.2 сая төгрөгийн орлого оруулсан нь орон нутгийн орлого давж биелэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Малын албан татварын орлогыг Сумын ИТХ-ын хуралдааны 2021 оны 20 тоот тогтоолоор “Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай” тогтоолд үндэслэн сумын Засаг даргын 2021 оны А/123 дугаар “Малын тоо толгойн албан татвар хураах тухай” захирамжаар татварын орлого бүрдүүлсэн байна. 2022 оноос сумын орон нутгийн орлогын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Сумын орон нутгийн орлогын ихэнх орлогууд тасарсан шалтгаан нь аймгаас баталсан орон нутгийн орлогын төлөвлөгөөг сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор үндэслэлгүйгээр нэмэгдүүлж баталсантай холбоотой тухайн орлого тасарсан гэх тайлбарыг өгч байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 34.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 233.2 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 25.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №8 Төсвийн байгууллагуудын 2021 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

*/сая төгрөг/*

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт

1	Сумын ИТХ	74.9	74.9	-
2	Сумын ЗДТГ	483.5	483.6	(0.1)
3	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	1,766.5	1,761.0	5.5
4	Ерөнхий боловсролын Согоог сургууль	978.4	977.3	1.1
5	Ерөнхий боловсролын Хөх хөтөлийн сургууль	1,243.0	1,239.7	3.3
6	Сумын Хүүхдийн цэцэрлэг	556.9	556.9	-
7	Согоог хүүхдийн цэцэрлэг	324.9	324.6	0.3
8	Хөх хөтөлийн хүүхдийн цэцэрлэг	292.2	292.2	-
9	Соёлын төв	90.1	90.1	-
10	Эрүүл мэндийн төв	1,024.4	1,018.6	5.8
11	ОНХСан	214.6	214.6	-
12	СХС	180.0	166.6	13.4
<b>Нийт дүн</b>		<b>7,229.4</b>	<b>7,200.1</b>	<b>29.3</b>

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 307.6 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 1.6 сая төгрөгийн, нийт 309.2 сая нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлс, НДШ-тэй холбоотой зардалд 79.0 сая, бичиг хэрэгт 1.6 сая, тээвэр шатахууны зардалд 1.6 сая, шуудан, холбоо, интернэтийн төлбөрт 0.6 сая, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалд 0.8 сая, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсд 0.7 сая, эмийн зардалд 32.3 сая, багаж, техник, хэрэгсэлд 2.3 сая, томилолт, бараа үйлчилгээний бусад зардалд 116.8 сая төгрөгийн, урсгал шилжүүлгийн зардалд 71.2 сая нийтдээ 309.2 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улаанхус сумын Засаг дарга нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 56 мэдээллийг хоцроож байршуулсан, Орон нутгийн хөгжлийн сангийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 109.1 сая төгрөгийн мэдээллийг оруулаагүй.

Мөн Сум хөгжүүлэх сангийн 166.6 сая төгрөгийн орлого, 178.2 сая төгрөгийн зарлагын гүйлгээний мэдээлэл болон тайлант онд олгосон зээлийн авлагын талаарх шийдвэр, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 44.9 сая төгрөгийн 3 гүйлгээ, зарлага санхүүжилтийн 125.5 сая төгрөгийн 13 гүйлгээний мэдээллийг огт оруулаагүй, Засаг даргын шилэн данс мэдээлсэн байдлын хэрэгжилт 44 хувьтай, өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус ТТЗ-ийн багцад хамаарах 14 байгууллага, санг хамруулан, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Тухайн ТТЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудитын дүнгээр 1 байгууллагад зөрчил арилгах албан шаардлага, 3 байгууллагад зөвлөмж өгөгдсөн байна.

**Аудитын илрүүлэлт:**

*ЕБ-ын 2 дугаар сургууль шилэн дансанд 3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийг хугацаа хоцроож оруулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 3.8 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 398.9 сая төгрөгийн 5 мэдээлэл, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй, 11.2 сая төгрөгийн авлага үүсгэсэн тухай шийдвэрийг байршуулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 66.7 хувьтай байна.*

*ЕБ-ын 3 дугаар сургууль шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 119 мэдээллийг байршуулахаас 114 мэдээллийг хугацаандаа байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, шилэн дансны хэрэгжилт 91.3 хувьтай байна.*

*Согог хүүхдийн цэцэрлэг цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 187.6 сая төгрөгийн гүйлгээний болон 3.7 сая төгрөгийн өр үүсгэсэн талаарх мэдээллийг оруулаагүй шилэн дансны хуулийн хэрэгжилт 89.5 хувьтай байна.*

*Эрүүл мэндийн төв шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оны эцсын 46.4 сая төгрөгийн авлага үүсгэсэн талаарх мэдээллийг байршуулаагүй байна.*

**3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт, албан шаардлага өгөгдөөгүй, 3 заалт бүхий зөвлөмж өгөгдсний 1 нь биелэгдэж, 2 нь биелэгдэгүй зөрчлийг давтан гаргасан байна. Зөвлөмжийн биелэлт 33.3 хувьтай байна.

*Хүснэгт: №8* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3		1		2		33.3

Нийт	3	1	2	33.3
------	---	---	---	------

/сая төгрөг/

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 10 төсвийн байгууллага, 4 тусгайн сангийн нийт 14 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 8 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, 3 дугаар сургууль, сумын хүүхдийн цэцэрлэг, Согог хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, Хөх хөтөлийн хүүхдийн цэцэрлэг “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Сумын ИТХ, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

#### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой залруулга гараагүй байна.

#### **Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой тайлантай холбоотой 625.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 625.1 сая төгрөгийн албан шаардлага, 1 заалттай зөвлөмж өгөгдлөө.

1. Улаанхус сумын Засаг дарга нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 56 мэдээллийг хоцроож байршуулсан, Орон нутгийн хөгжлийн сангийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 109.1 сая төгрөгийн мэдээллийг оруулаагүй.

Сум хөгжүүлэх сангийн 166.6 сая төгрөгийн орлого, 178.2 сая төгрөгийн зарлагын гүйлгээний мэдээлэл болон тайлант онд олгосон зээлийн авлагын талаарх шийдвэр, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 44.9 сая төгрөгийн 3 гүйлгээ, зарлага санхүүжилтийн 125.5 сая төгрөгийн 13 гүйлгээний мэдээллийг огт оруулаагүй, Засаг даргын шилэн данс мэдээлсэн байдлын хэрэгжилт 44 хувьтай, өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байна.

2. Сумын Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүд дотуур байр болон цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний материалыг хэрэгцээнээс илүү нөөцөлж бараа материалын үлдэгдлийг их хэмжээгээр нэмэгдүүлсэн нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэн, нөгөө талаар сумын санхүү, төрийн сангаас нормативт зардлын төсвийн зарцуулалтад хүүхэд өдрийн гүйцэтгэлээр хяналт тавьж ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 5.1.4-т “мэдээллийг тогтмол шинэчилж байх”, 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 7.1-д “Шилэн дансны

мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалт болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох гэсэн заалт,

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв.**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийтдээ 557.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

ЕБ-ын 2 сургуульд 17.4 сая, сумын хүүхдийн цэцэрлэгт 8.7 сая, Согог хүүхдийн цэцэрлэгт 4.8 сая нийт 30.9 сая төгрөгийн залруулга хийгдэж, ЕБ-ын 2 дугаар сургуульд 1.4 сая төгрөгийн акт тогтоож, ЕБ-ын 2 дугаар сургуульд 23.7 сая, 3 дугаар сургуульд 13.5 сая, Согог хүүхдийн цэцэрлэгт 23.1 сая, Хөх хөтөлийн хүүхдийн цэцэрлэгт 86.5 сая, Эрүүл мэндийн төвд 7.8 сая төгрөгийн нийт 154.6 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдсөн.

ЕБ-ын 1 дүгээр сургуульд 70.4 сая, 3 дугаар сургуульд 6.1 сая, сумын Хүүхдийн цэцэрлэг 59.7 сая, Эрүүл мэндийн төвд 46.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 6 заалттай зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт 8: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	2	70.4							2	70.4
2	ЕБ-ын 2 дугаар сургууль	6	42.5	2	17.4	1	1.4	3	23.7		
3	ЕБ-ын 3 дугаар сургууль	2	19.6					1	13.5	1	6.1
4	Улаанхус сумын хүүхдийн цэцэрлэг	2	68.4	1	8.7					1	59.7
5	Согоог хүүхдийн цэцэрлэг	4	215.5	1	4.8			2	23.1	1	187.6
6	Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг	2	86.5					2	86.5		
7	Эрүүл мэндийн төв	2	54.2					1	7.8	1	46.4
<b>Нийт дүн</b>		<b>20</b>	<b>557.1</b>	<b>4</b>	<b>30.9</b>	<b>1</b>	<b>1.4</b>	<b>9</b>	<b>154.6</b>	<b>6</b>	<b>370.2</b>

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

##### 1. Албан тушаалын чиг үүргийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

###### 1.1. Илрүүлэлт:

Сумын Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн 2 дугаар гарын үсгийг Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч зурж, тайлан баланс гаргаж ирүүлсэн байна.

Энэ нь Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Санхүүгийн албаны даргын ажлын байрны тодорхойлолтын албан тушаалын 2 дугаар зорилтын 12, 3 дугаар зорилтын 1-д заасныг зөрчсөн байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан сумын Санхүүгийн албаны ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны даргаар зуруулж, тайлан, баланс гаргуулах зөрчлийг арилгаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Улаанхус сумын ТТЗСНТайлан	3	625.1					2	625.1	1	